

ИРГЭНИЙ БОЛОН ХУДАЛДААНЫ ХЭРГИЙН ТАЛААР ЭРХ ЗҮЙН ТУСЛАЛЦАА ХАРИЛЦАН ҮЗҮҮЛЭХ ТУХАЙ МОНГОЛ УЛС, БҮГД НАЙРАМДАХ СОЛОНГОС УЛС ХООРОНДЫН ГЭРЭЭ

Монгол Улс, Бүгд Найрамдах Солонгос Улс нь /цаашид “Талууд” гэнэ/

Бүрэн эрхт байдал болон эрх тэгш, харилцан ашигтай байх зарчмыг хүндэтгэн үзэх үндсэн дээр иргэний болон худалдааны хэргийн талаар хоёр улсын шүүхийн байгууллагуудын хамтын ажиллагааг улам бүр бэхжүүлэхийг эрмэлзэн,

Дараахь зүйлийн талаар тохиролцов. Үүнд:

1 дүгээр бүлэг. Нийтлэг заалтууд

1 дүгээр зүйл Шүүхэд хандах эрх

1. Нөгөө Талын нутаг дэвсгэр дээр байгаа аль нэг талын иргэн нь нөгөө Талын иргэнтэй адил тэгш нөхцлөөр тухайн Талын шүүхэд хандах эрхтэй.
2. Аль нэг Тал нь нөгөө талын Иргэдийн оролцоо бүхий аливаа шүүх ажиллагааг хүндэтгэх шалтгаангүйгээр саатуулахгүй.
3. Талуудын иргэдэд хамаарах энэхүү гэрээний заалтууд нь аль нэг талын нутаг дэвсгэр дээр түүний дотоодын хуулийн дагуу байгуулагдсан хуулийн этгээдэд нэгэн адил хамаарна.

2 дугаар зүйл Гэрээний хамрах хүрээ

Энэхүү гэрээний заалтуудын дагуу Талууд нь шүүхийн баримт бичиг гардуулах, нотлох баримт авах, иргэн, худалдааны хэргийн талаарх хууль зүйн болон шүүхийн мэдээллийг солилцохтой холбогдсон асуудлаар харилцан туслалцаа үзүүлнэ.

3 дугаар зүйл Эрх зүйн туслалцаа

1. Аль нэг Талын иргэн нь нөгөө талын нутаг дэвсгэр дээр аливаа эрх зүйн туслалцааг тухайн Талын дотоодын хуулийн дагуу авах эрхтэй.
2. Энэ зүйлийн 1 дүгээр хэсэгт заасны дагуу эрх зүйн туслалцаа хүссэн хүсэлтэд хүсэлт гаргагчийн оршин суудаг, эсхүл амьдардаг нутаг дэвсгэрийг харъяалах Талын эрх бүхий байгууллагаас гаргасан санхүүгийн чадамжийн талаархи тодорхойлолтыг хавсаргана. Хэрэв хүсэлт гаргагч нь аль нэг Талын нутаг дэвсгэрт оршин суудаггүй бол энэхүү тодорхойлолтыг тухайн хүсэлт гаргагчийн харъяалах Талын дипломат, эсхүл консулын ажилтан олгох буюу нотолно.

3. Эрх зүйн туслалцаа хүссэн хүсэлтийг хүлээн авч шийдвэрлэх эрх бүхий байгууллага тухайн хүсэлт гаргагчаас нэмэлт мэдээлэл шаардаж болно.

4 дүгээр зүйл

Шүүхийн туслалцаа үзүүлэх зорилгоор харилцах байгууллагууд

1. Энэхүү гэрээнд өөрөөр заагаагүй бол Талууд өөрсдийн томилсон харилцах эрх бүхий байгууллагаараа дамжуулан шүүхийн туслалцаа авах, эсхүл шүүхийн туслалцаа үзүүлэх зорилгоор шууд харилцана.
2. Монгол Улсын хувьд эрх бүхий төв байгууллага нь Монгол Улсын Дээд Шүүх, Бүгд Найрамдах Солонгос Улсын хувьд эрх бүхий төв байгууллага нь Үндэсний шүүхийн захиргаа тус тус байна.
3. Аль нэг тал нь нөгөө Талдаа бичгээр мэдэгдэх замаар харилцан эрх бүхий өөр Төв байгууллагыг томилж болох бөгөөд түүний эрхийн хамрах хүрээг дипломат шугамаар мэдэгдэнэ.
4. Талууд өөрийн харилцах эрх бүхий Төв байгууллага өөрчлөгдсөн тохиолдолд энэ талаар нөгөө талдаа нэн даруй мэдэгдэнэ.

5 дугаар зүйл

Шүүхийн туслалцаа үзүүлэхээс татгалзах

1. Хэрэв шүүхийн туслалцаа хүссэн хүсэлт нь Хүлээн авагч талын тусгаар тогтнол, аюулгүй байдал, нийгмийн дэг журамд аюул учруулахуйц, эсхүл тухайн хүсэлт нь шүүхийн байгууллагын үндсэн чиг үүрэгт хамаарахгүй гэж үзвэл шүүхийн туслалцаа үзүүлэхээс татгалзаж болох бөгөөд татгалзах болсон шалтгаанаа Хүсэлт гаргагч талд мэдэгдэнэ.
2. Шүүхийн баримт бичиг гардуулах, гэрчийн мэдүүлэг авах асуудлаар шүүхийн туслалцаа хүссэн хүсэлтийг зөвхөн хүсэлт хүлээн авагч Талын шүүх нь нэхэмжлэлд тусгагдсан асуудлаар шүүхийн онцгой харъяалал эдэлдэг, эсхүл хүсэлт гаргасан нэхэмжлэлийг дотоодын хуулийн дагуу зөвшөөрөхгүй гэсэн үндэслэлээр Хүсэлт хүлээн авагч Тал хүсэлтийг хүлээн авахаас татгалзаж болохгүй.

6 дугаар зүйл

1. Хүсэлт хүлээн авагч талын эрх бүхий Төв байгууллага нь аливаа хүсэлтийг энэхүү гэрээний заалтуудтай нийцэхгүй байна гэж үзвэл энэ талаар Хүсэлт гаргагч талын эрх бүхий Төв байгууллагад нэн даруй мэдэгдэж татгалзах болсон шалтгааныг тодорхой дурьдана.
2. Хүсэлт хүлээн авагч талын эрх бүхий төв байгууллага нь Гэрээнд заасны дагуу хүсэлтийг хүлээн авахад ирүүлсэн мэдээлэл нь алдаатай, хангалтгүй байна гэж үзвэл хүсэлтэд дурьдагдсан мэдээллийн үнэн зөвийг нягтлан шалгаж, Хүсэлт гаргагч талын эрх бүхий байгууллагаас нэмэлт мэдээлэл шаардаж болно.
3. Хүсэлт гаргагч Талын эрх бүхий Төв байгууллага нь энэ зүйлийн 1, 2 дугаар хэсэгт заасны дагуу холбогдох арга хэмжээ авсан, хүсэлтийг хүлээн авч хэрэгжүүлэхэд учруулж болох аливаа саад бэрхшээлийг арилгах зорилгоор залруулсан, эсхүл нэмэлт мэдээлэл гаргаж өгсөн бол Хүсэлт хүлээн авагч талын эрх бүхий Төв байгууллага хүсэлтийг хүлээн авч холбогдох арга хэмжээг авна.
4. Хүсэлт хүлээн авагч Талын эрх бүхий Төв байгууллага нь хүсэлтийг хүлээн авч хэрэгжүүлэхэд тодорхой хугацаа шаардлагатай болсон бол энэ тухай хүсэлт гаргагч Талын эрх бүхий байгууллагад нэн даруй мэдэгдэнэ.
5. Хүсэлт гаргагч Талын эрх бүхий Төв байгууллага нь хүсэлтийг хангах талаар авч байгаа арга хэмжээний явцын талаарх мэдээллийг Хүсэлт хүлээн авагч талын эрх бүхий төв байгууллагаас хүсч болно.

7 дугаар зүйл

Харилцах хэл

1. Хүсэлт болон түүнийг дагалдах баримт бичгүүдийг Хүсэлт гаргагч талын хэлээр үйлдэх бөгөөд уг хүсэлтэд хүлээн авагч талын албан ёсны хэл, эсхүл англи хэлээр орчуулгыг хавсаргана.
2. Хүсэлт болон дагалдах баримт бичгүүдийн орчуулгыг Хүсэлт гаргагч Талын дотоодын хууль болон тогтсон аливаа практикийн дагуу хянан баталгаажуулна. Албажуулах, эсхүл түүнтэй адилтгах нотолгоог шаардахгүй.
3. Аль нэг Талын эрх бүхий байгууллагаас бичгээр илгээж буй аливаа баримт бичгийг нөгөө Талын албан ёсны хэл, эсхүл англи хэлээрх орчуулгын хамтаар нөгөө Талын эрх бүхий Төв байгууллагад шууд илгээнэ.
4. Шүүхийн даалгаварыг гардуулсан болохыг нотолсон баталгаа бүхий хүсэлтийн хариуг Хүсэлт хүлээн авагч талын албан ёсны хэлээр үйлдэж болох бөгөөд энэ тохиолдолд хариу бичгийн орчуулгыг Хүсэлт гаргагч Талын албан ёсны хэл, эсхүл англи хэлээр үйлдэж хавсаргана.

8 дугаар зүйл

Хураамж буюу зардал

1. Хүсэлтийг хангахад энэ зүйлийн 2 дахь хэсэгт зааснаас бусад тохиолдолд үүссэн аливаа хураамж, зардлыг нөхөн төлөхөд асуудал үүсэхгүй.
2. Хүсэлт хүлээн авагч Тал нь Хүсэлт гаргагч талаас дараахь хураамж, зардлыг нөхөн төлөхийг шаардаж болно. Үүнд:
 - a. Баримт бичиг гардуулах ажиллагаа явагдсан, эсхүл гардуулах оролдлого хийх үедээ:
 - i. Хүсэлт хүлээн авагч Талын хуульд заасны дагуу шүүхийн ажилтан, эсхүл эрх бүхий хүнийг ажиллуулсан бол;
 - ii. Хүсэлтэд заасны дагуу баримт бичиг гардуулахдаа тусгай арга хэрэглэсэн бол;
 - b. Гэрчийн мэдүүлэг авах үедээ:
 - i. Шинжээч, эсхүл орчуулагчийн тусламж авсан бол;
 - ii. Хүсэлтэд заасны дагуу тусгай журам хэрэглэсэн бол.
3. Аль нэг хүсэлтийг хангахад үлэмж их хэмжээний зардал гарах нь тодорхой болсон бол Талууд хүсэлтийг хэрэгжүүлэх болзол, нөхцлийг тодорхойлох зорилгоор зөвлөлдөнө.
4. Хүсэлт хүлээн авагч Тал нь хүсвэл Хүсэлт гаргагч талын хүсэлтийг хангахад гаргах зардал, өртгийг урьдчилан төлнө.

9 дүгээр зүйл **Дипломат шугамаар харилцах эрх**

Энэхүү гэрээ нь Талууд шүүхийн туслалцаа хүсэх асуудлаар дипломат шугамаар харилцахад саад учруулахгүй.

Бүлэг II. Шүүхийн баримт бичиг гардуулах

10 дугаар зүйл **Баримт бичиг гардуулах**

Аль нэг талын нутаг дэвсгэрт үйлдсэн шүүхийн баримт бичгийг нөгөө Талын нутаг дэвсгэрт гардуулахаар бол тухайн баримт бичгийг энэхүү Гэрээний 11, 15 дугаар зүйлд заасны дагуу хүргүүлэн гардуулж болно.

11 дүгээр зүйл **Хүсэлт гаргах**

Дотоодын эрх бүхий байгууллагаас гаргасан хүсэлтийг Хүсэлт гаргагч Талын эрх бүхий Төв байгууллага нь Хүсэлт авагч талын эрх бүхий Төв байгууллагад шууд илгээж болно.

12 дугаар зүйл **Хүсэлтийн агуулга, хэлбэр**

1. Шүүх баримт бичиг гардуулах тухай хүсэлтийг энэхүү гэрээний 1 дүгээр хавсралтад дурьдсаны дагуу үйлдэнэ.
2. Хүсэлтэд гардуулах баримт бичгийг хавсаргана.

13 дугаар зүйл **Баримт бичгийг гардуулах хүсэлтийг хангах**

1. Энэхүү гэрээний заалтын дагуу зохих ёсоор гаргасан хүсэлтийг хангах талаар шуурхай арга хэмжээ авна.
2. Хүсэлтийг хангахдаа Хүсэлт хүлээн авагч талын хууль тогтоомжид заасны дагуу, эсхүл Хүсэлт хүлээн авагч Талын хууль тогтоомжид харшлаагүй Хүсэлт гаргагч талын тусгайлан хүссэн аргыг хэрэглэж болно.
3. Хүсэлтийг нэг хэсэг болох баримт бичгийн хураангуйг гардуулах баримт бичгүүдэд хавсаргана.
4. Тухайн хүсэлт нь түүнийг хүлээн авсан эрх бүхий байгууллагын чиг үүрэгт хамаарахгүй байвал уг хүсэлтийг эрх бүхий байгууллагад шилжүүлнэ.

14 дүгээр зүйл

1. Хүсэлт хүлээн авагч Талын эрх бүхий Төв байгууллага энэхүү гэрээний 4 дүгээр зүйлд заасны дагуу Хүсэлт гаргагч талын эрх бүхий Төв байгууллагад энэхүү гэрээний 2 дугаар хавсралтанд дурьдсаны дагуу хүсэлтийг хангасан тухай мэдэгдэх, эсхүл хүсэлтийг хангахад тулгарч байгаа бэрхшээлийн талаар мэдэгдэнэ. Уг албан бичгийн хувийг факсаар, эсхүл цахим шуудангаар урьдчилан илгээх бөгөөд эх хувийг шуудангаар явуулна.

2. Хэрэв баримт бичгийг гардуулсан бол хүлээн авагчийн нэр, биеийн байцаалт болон гардуулсан огноо, газар, аргыг албан бичигт тодорхой дурьдана.
3. Хэрэв баримт бичгийг гардуулаагүй бол учирсан бэрхшээл, шалтгааныг тодорхой дурьдсан албан бичгээр баримт бичгийг Хүсэлт гаргагч талд буцаан хүргүүлнэ.

15 дугаар зүйл

Дипломат, эсхүл консулын ажилтнаар дамжуулах

1. Хэрэв энэ нь тухайн Талын хуультай зөрчилдөөгүй болон албадлагын ямар нэгэн арга хэмжээ аваагүй тохиолдолд Талууд нөгөө талын нутаг дэвсгэрт байгаа өөрсдийн иргэдэд холбогдох шүүхийн баримт бичгийг өөрийн дипломат, эсхүл консулын ажилтнаар дамжуулан гардуулан өгч болно.
2. Энэ зүйлийн 1 дэхь хэсэгт заасны дагуу гардуулах баримт бичигт хүлээн авагч этгээдийн оршин суугаа Талын албан ёсны хэлээр орчуулсан орчуулгыг хавсаргах шаардлагагүй.

Бүлэг III. Нотлох баримт

16 дугаар зүйл

Нотлох баримт

1. Энэхүү гэрээний дагуу аль нэг Тал нь нөгөө талын гаргасан хүсэлтийг хангахдаа өөрийн нутаг дэвсгэр дээр хэргийн зохигчдоос мэдээлэл авах, гэрчийн мэдүүлэг авах, эд материалын болон бичгээр нотлох баримт авах, шинжээчийн дүгнэлт гаргуулах, шүүхийн үзлэг хийлгэх, тодорхой баримтуудыг шаардах замаар төрийн байгууллагаар нягтлан шалгуулах буюу нотлох баримт цуглуулах зорилгоор шаардлагатай бусад арга хэмжээг авна.
2. Энэхүү гэрээ нь дараахь асуудалд хамаарахгүй. Үүнд:
 - a. Тухайн хэргийг хянан шийдвэрлэх ажиллагаанд шаардлагагүй асуудлаар нотлох баримт цуглуулах, эсхүл
 - b. Хүсэлтэд дурьдаагүй, эсхүл тухайн хэргийг хянан шийдвэрлэх ажиллагаатай шууд уялдаа холбоогүй асуудлаар бичиг баримт авах.

17 дугаар зүйл

Хүсэлт гаргах

Аль нэг талын эрх бүхий Төв байгууллага нөгөө Талын эрх бүхий Төв байгууллагад хандан нотлох баримт авах тухай хүсэлтийг гаргаж болно.

18 дугаар зүйл

Хүсэлтэд тусгавал зохих мэдээлэл

1. Хүсэлтэд дараахь мэдээллийг оруулсан байна. Үүнд:
 - a. Хүсэлт гаргагч шүүхийн нэр, хаяг, утас, факсын дугаар, хэрэв боломжтой бол цахим шуудангийн хаяг зэрэг холбоо барихад шаардлагатай бусад мэдээлэл;
 - b. Хэргийг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцогч талуудын нэр, хаяг, хэрэв боломжтой бол тэдгээрийн төлөөлөгчдийн нэр, хаяг;
 - c. Хянан шийдвэрлэх ажиллагааны шинж чанар, боломжтой бол нэхэмжлэлийн үнийн дүн;
 - d. Цуглуулах ёстой нотлох баримтын шинж чанар.
2. Хүсэлтэд боломжтой бол дараахь мэдээллийг тусгасан байна. Үүнд:
 - a. Хариуцагч талын нэр хаяг, утас, факсын дугаар, боломжтой бол цахим шуудангийн хаяг зэрэг холбоо барихад шаардлагатай бусад мэдээлэл;
 - b. Хариуцагч талд тавих асуултууд, эсхүл хариуцагчид холбогдох хэргийн нэхэмжлэл;
 - c. Шалгагдах баримт бичиг, эсхүл бусад хувийн болон үл хөдлөх эд хөрөнгийн шинж чанар;
 - d. Дагаж мөрдвөл зохих тусгай арга, журам;
 - e. 8 дугаар зүйлд заасан арга хэмжээг авахад гарах хураамж, зардлын тооцоо;
 - f. Хүсэлтийг хангахад шаардагдах бусад нэмэлт мэдээлэл

19 дүгээр зүйл

Нотлох баримт авах хүсэлтийг хангах

1. Энэхүү гэрээний заалтуудын дагуу зохих ёсоор үйлдсэн хүсэлтийг хангах арга хэмжээг нэн даруй авна.

2. а. Хүсэлтийг хангахдаа хүсэлт хүлээн авагч Тал нь дотоодын хуульд заасны дагуу холбогдох арга хэмжээ авах, эсхүл Хүсэлт хүлээн авагч Талын хууль тогтоомжид харшлаагүй болон бодит шалтгааны улмаас хэрэгжүүлэх боломжгүйгээр бусад тохиолдолд Хүсэлт гаргагч талын санал болгосон тусгай аргыг хэрэглэнэ.
б. Хүсэлт хүлээн авагч Тал нь хүсэлтийг хангахад шүүхэд туслалцаа үзүүлэх зорилгоор өмгөөлөгчдийг томилон ажиллуулж болно.
3. Тухайн хүсэлт нь түүнийг хүлээн авсан эрх бүхий байгууллагын чиг үүрэгт хамаарахгүй байвал уг хүсэлтийг эрх бүхий байгууллагад шилжүүлнэ.
4. Хүсэлтийг бүхэлд нь, эсхүл хэсэгчлэн хангаагүй тохиолдолд хүсэлт хүлээн авагч Талын эрх бүхий Төв байгууллага нь Хүсэлт гаргагч талын эрх бүхий Төв байгууллагад хүсэлтийг хангаагүй шалтгааныг нэн даруй мэдэгдэнэ.

20 дугаар зүйл.

Оролцоо

1. а. Шүүх хүсэлтийг хангахдаа зохигчид болон тэдгээрийн хууль ёсны төлөөлөгчдийг байлцуулж болно.
б. Хүсэлт гаргагч талын шүүхийн ажилтан хүсэлт хүлээн авагч талын зөвшөөрлийг урьдчилан авсаны үндсэн дээр нотлох баримтыг бүрдүүлэх зорилгоор шүүхийн хүсэлтийг хангах үед байлцаж болно.
2. Хүсэлтийг хангах үед дээрх хүсэлтийг тавьсан бол Хүсэлт хүлээн авагч Талын эрх бүхий байгууллага нь нотлох баримт авах цаг хугацаа, газрын талаар Хүсэлт гаргагч Талын эрх бүхий Төв байгууллагад бололцооны хэрээр мэдэгдэнэ.
3. Зохигчид, тэдгээрийн хууль ёсны төлөөлөгчид болон шүүхийн ажилтан нар нь шүүхийн хүсэлтийг хангах ажиллагаанд оролцохдоо Хүсэлт хүлээн авагч талын хуулийг сахин биелүүлнэ.

21 дүгээр зүйл

Албадлагын арга хэмжээ

Хүсэлт хүлээн авагч талын шүүх нь хүсэлтийг хангахдаа өөрийн эрх бүхий төв байгууллагаас гаргасан шийдвэрийн хүрээнд, эсхүл зохигчдын хүсэлтээр дотоодын хууль тогтоомжийн дагуу шаардлагатай албадлагын арга хэмжээг бүхий л шатанд авна.

22 дугаар зүйл

Гэрчийн этгээдийн эрх, гэрчийн мэдүүлэг өгөхөөс татгалзах

Шүүхийн хүсэлтийг хангах үед холбогдох этгээд нь гэрчийн мэдүүлэг өгөхөөс татгалзах асуудлаар дараахь эрх эдэлж, үүргийг хүлээнэ:

- а) Хүсэлт хүлээн авагч улсын хуульд заасны дагуу, эсхүл
- б) Хүсэлт гаргагч талын хуульд зааснаар дараахь тохиолдолд:
 - i. Хүсэлтэд тодорхойлсон үүргийн хүрээнд, эсхүл
 - ii. Хүсэлт хүлээн авагч талын эрх бүхий Төв байгууллагын тухайн шатанд Хүсэлт гаргагч Талын эрх бүхий Төв байгууллагаас эрх бүхий этгээдэд өөрөөр тодорхойлж хүргүүлсэн эрх, үүргийн хүрээнд.

23 дугаар зүйл

Нотолгоо

1. Хүсэлт хүлээн авагч талын эрх бүхий Төв байгууллага баримт бичиг гардуулсан, нотлох баримт авсан, хүсэлтийг бүхэлд нь, эсхүл хэсэгчлэн хангахад учирсан саад тотгорын шалтгааныг тайлбарласан нотолгоог хүсэлт гаргагч талын эрх бүхий төв байгууллагад явуулна. Тухайн нотолгооны эх хувийг шуудангаар илгээхээс өмнө хувийг факс, эсхүл цахим шуудангаар илгээнэ.
2. Хүсэлтийг хангасан тухай гэрчилсэн нотолгоонд баримт бичиг гардуулсан хүний овог нэр, гардуулсан огноо, хүсэлтийг хэрхэн хангасан талаархи асуудлыг тодорхой тусгана.

24 дүгээр зүйл

Дипломат эсхүл консулын ажилтнаар нотлох баримтыг авахуулах

Аль нэг талын дипломат, эсхүл консулын ажилтан нөгөө талын нутаг дэвсгэр дээр албадлагын бус аргаар тухайн ажилтны төлөөлөн суугаа талд эхлүүлсэн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд тус болох зорилгоор өөрийн улсын иргэнээс нотлох баримтыг гаргуулж болох бөгөөд ингэхдээ тухайн Талын хуулийг зөрчихгүй, албадлагын ямар нэг арга хэмжээ авахгүй.

25 дугаар зүйл

Хууль ёсны төлөөлөгч

Энэ бүлгийн аливаа зүйлийн дагуу нотлох баримтыг бүрдүүлж авахад холбогдох этгээдийг хууль ёсны төлөөлөгч нь төлөөлж болно.

Бүлэг IV. Бусад заалтууд

26 дугаар зүйл

Баримт бичгийн үнэн зөвийг гэрчлэхээс чөлөөлөх

Энэхүү гэрээний зорилгоор Талуудын шүүх, эсхүл эрх бүхий бусад байгууллагаас үйлдсэн, эсхүл нягтлан шалгаад энэхүү Гэрээний 4 дүгээр зүйлд заасан захидал харилцааны шугамаар шилжүүлсэн баримт бичгүүд нь аливаа хууль зүйн гэрчлэлтээс чөлөөлөгдөнө.

27 дугаар зүйл

Хууль болон хавталт хэргийн талаар мэдээлэл авахаар хүсэлт гаргах

1. Хүсэлт хүлээн авагч Талын эрх бүхий байгууллага нь Хүсэлт гаргагч талын эрх бүхий Төв байгууллагаас ирүүлсэн хүсэлтийн дагуу хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаатай холбоотой дотоодын хууль тогтоомжийн талаархи мэдээллийг хүргүүлнэ.
2. Хүсэлт гаргагч талаас хүсэлт хүлээн авагч талын харъяалах шүүхийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцсон өөрийн иргэний талаархи олон нийтэд нээлттэй шүүхийн тэмдэглэлийн хуулбарыг Хүсэлт хүлээн авагч талын эрх бүхий төв байгууллагаас хүсвэл холбогдох мэдээллийг хүсэлт гаргагч талд гаргаж өгнө.

28 дугаар зүйл

Бусад гэрээ

Энэхүү Гэрээтэй холбоотой аливаа асуудлаар Талуудын хооронд байгуулсан болон цаашид байгуулах хоёр талын болон олон талт гэрээ, хэлэлцээр, тэдгээрийн хооронд тогтсон аливаа практикт энэхүү гэрээ нь үл хамаарна.

29 дүгээр зүйл

Маргаан шийдвэрлэх

Энэхүү гэрээг тайлбарлах хэрэгжүүлэх явцад Талуудын хооронд үүсч болох аливаа маргааныг дипломат шугамаар эв зүйгээр шийдвэрлэнэ.

Бүлэг V. Төгсгөлийн заалтууд

30 дугаар зүйл

Хүчин төгөлдөр болох, цуцлах

1. Энэхүү гэрээг соёрхон батална. Соёрхон баталсан тухай Батламж жуух бичгийгсолилцоно. Соёрхон баталсан тухай Батламж жуух бичгийг солилцсон өдрөөс хойш 30 хоногийн дараа энэхүү гэрээ хүчин төгөлдөр болно.
2. Энэхүү гэрээ нь түүнийг хүчин төгөлдөр болохоос өмнө эхэлсэн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд нэгэн адил хамаарна.
3. Аль нэг тал нь энэхүү гэрээг цуцлах тухайгаа дипломат шугамаар хэдийд ч бичгээр мэдэгдэж болно. Ийнхүү мэдэгдсэн өдрөөс хойш нэг зуун наян өдрийн дараа энэхүү Гэрээ цуцлагдсанд тооцогдоно.
4. Энэхүү гэрээ цуцлагдсан эсэхээс үл хамааран гэрээ цуцлагдахаас өмнө хүлээн авсан аливаа хүсэлтийг энэхүү Гэрээний заалтуудын дагуу хэрэгжүүлнэ.

ДЭЭРХИЙГ НОТЛОН, тус улсын Засгийн газраас зохих ёсоор эрх олгогдсон доорхи албан тушаалтнууд энэхүү Гэрээнд гарын үсэг зурав.

Энэхүү гэрээг 2008 оны 10 дугаар сарын 15-ны өдөр Сөүл хотноо монгол, солонгос, англи хэлээр тус бүр хоёр хувь үйлдсэн бөгөөд эх бичвэрүүд нь адил хүчинтэй байна. Тайлбарлахад зөрүү гарвал англи хэлээрх эх бичвэр давуу хүчинтэй байна.

Монгол Улсын төлөөлж:

БНСУ-ыг төлөөлж:

.....

.....